



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2023/02/НА-СТА-ОНӨ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512127 Цахим хаяг: zolzayau@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>8</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>10</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>10</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>10</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....</b>	<b>11</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>11</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>11</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>11</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>11</b>
<b>5.1 Төлбөрийн акт.....</b>	<b>12</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>12</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА  
ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ С.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

2023.03.22 № 158  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийв.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 онд “Дотоод хяналт, шалгалт хийх журам” батлуулж, төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцож ажилласан байна.

## Аудитын гол асуудал

Гүйцэтгэлээр 265,468.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 301,171.2 мянган төгрөгийн зардал гарган, 35,703.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## Бусад асуудлын хэсэг

Дарьганга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,998,344.13</b>	<b>20,725,970.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>301,409.29</b>	<b>383,428.38</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>301,409.29</b>	<b>383,428.38</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>301,409.29</b>	<b>383,428.38</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	301,409.29	383,428.38
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>12,200,481.84</b>	<b>9,358,981.82</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	371,245.66	0.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>11,829,236.18</b>	<b>9,358,981.82</b>
33510	Байгууллагаас авах авлага	11,829,236.18	9,358,981.82
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>9,496,453.00</b>	<b>10,983,560.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>9,496,453.00</b>	<b>10,983,560.00</b>
35420	Аж ахуйн материал	9,496,453.00	10,983,560.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>776,417,354.58</b>	<b>760,928,490.78</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>776,417,354.58</b>	<b>760,928,490.78</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>771,725,196.25</b>	<b>746,683,232.45</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	942,988,171.00	942,988,171.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-182,867,141.42	-243,822,855.22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	39,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-1,662,500.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	18,175,000.00	18,475,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,570,833.33	-9,194,583.33
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,692,158.33</b>	<b>14,245,258.33</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	5,093,200.00	14,838,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-401,041.67	-593,541.67
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>798,415,698.71</b>	<b>781,654,460.98</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>794,906,358.43</b>	<b>804,102,486.89</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>794,906,358.43</b>	<b>804,102,486.89</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>34,864,203.85</b>	<b>67,591,046.12</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>34,864,203.85</b>	<b>67,591,046.12</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	32,130,608.00	55,204,705.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	2,733,595.85	12,386,341.12
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>760,042,154.58</b>	<b>736,511,440.77</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	760,042,154.58	736,511,440.77
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,509,340.28</b>	<b>-22,448,025.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,509,340.28</b>	<b>-22,448,025.91</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,075,000.00	11,820,600.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,434,340.28</b>	<b>-34,268,625.91</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-28,199,931.56	1,434,340.28
51220	Тайлант үеийн үр дүн	29,634,271.84	-35,702,966.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>798,415,698.71</b>	<b>781,654,460.98</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>96,363,059.53</b>	<b>56,196,387.15</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>96,363,059.53</b>	<b>56,196,387.15</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>96,363,059.53</b>	<b>56,196,387.15</b>

120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	265,434,401.05	265,468,242.38
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	169,071,341.52	209,271,855.23
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>56,728,787.69</b>	<b>91,899,353.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>56,728,787.69</b>	<b>91,899,353.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>56,728,787.69</b>	<b>91,899,353.34</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>56,728,787.69</b>	<b>91,899,353.34</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	54,787,510.21	89,861,451.18
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	1,941,277.48	2,037,902.16
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>39,634,271.84</b>	<b>-35,702,966.19</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,000,000.00</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	10,000,000.00	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>29,634,271.84</b>	<b>-35,702,966.19</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-26,124,931.56	-26,124,931.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-2,075,000.00	-2,075,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-28,199,931.56	-28,199,931.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	2,075,000.00	0.00	0.00	2,075,000.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	29,634,271.84	29,634,271.84
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,075,000.00	0.00	1,434,340.28	3,509,340.28
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,075,000.00	0.00	1,434,340.28	3,509,340.28
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,075,000.00	0.00	1,434,340.28	3,509,340.28
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	9,745,600.00	0.00	0.00	9,745,600.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-35,702,966.19	-35,702,966.19
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,820,600.00	0.00	-34,268,625.91	-22,448,025.91

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>293,700,101.24</b>	<b>301,386,213.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>293,700,101.24</b>	<b>301,386,213.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>293,700,101.24</b>	<b>301,386,213.77</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>12,783,131.00</b>

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	12,783,131.00
120009	Бусад орлого	15,980,944.75	0.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	277,719,156.49	288,603,082.77
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>303,573,346.22</b>	<b>301,304,194.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>303,573,346.22</b>	<b>301,304,194.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>303,573,346.22</b>	<b>301,304,194.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>62,032,012.07</b>	<b>80,391,361.50</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	62,032,012.07	80,391,361.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,976,139.54</b>	<b>22,571,353.79</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	16,976,139.54	22,571,353.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,809,680.88</b>	<b>11,996,605.51</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	13,809,680.88	11,996,605.51
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>163,593,815.70</b>	<b>147,405,979.73</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	55,572,713.60	80,967,290.68
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	108,021,102.10	66,438,689.05
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>47,161,698.03</b>	<b>38,938,894.15</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	27,601,814.03	34,056,794.15
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	19,559,884.00	4,882,100.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-9,873,244.98</b>	<b>82,019.09</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-9,873,244.98</b>	<b>82,019.09</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,174,654.27	301,409.29
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	301,409.29	383,428.38

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн	Хэмжих нэгж	2022 он	
			төлөвлөгөө	гүйцэтгэл
	Үзүүлэлт			
1	Нийт орлого: Үүнээс:	мян.төг	267,012.8	265,468.2
1.1	Дулаан үйлдвэрлэлээс	мян.төг	247,412.8	241,371.4
1.2	Туслах үйлчилгээнээс	мян.төг	19,600.0	24,096.8
2	Нийт зардал Үүнээс:	мян.төг	261,123.1	299,133.3
2.1	Удирдлагын зардал	мян.төг	101,194.7	89,861.5
3	Татварын өмнөх ашиг алдагдал	мян.төг	5,781.7	(33,665.1)
4	Цэвэр ашиг алдагдал	мян.төг	5,203.6	(35,703.0)
6	Нийт ажиллагсдын тоо		16.0	16.0
7	Нийт цалингийн сан	мян.төг	92,251.0	96,702.9
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	5,765.7	6,043.9
9	Борлуулалтын нэг төгрөгт ноогдох зардал өссөн буурсан		1.0	1.1
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	13,000.0	-
11	Нийт авлага	мян.төг		9,359.0
12	Нийт өглөг	мян.төг		67,591.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 ОНӨААТҮГ түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймгийн Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн зорилго нь Дарьганга сумын ААНБ, айл өрхийг дулаанаар тасралтгүй найдвартай хангаж, цаашид сумынхаа бүх айл өрх ААН-ийг дулаанд холбож, байгууллага, иргэдийн тав тухтай нөхцөлийг хангах, байгаль орчны эрүүл, цэвэр үзэмжтэй байдлыг бий болгосон байгууллага болно гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг төрийн захиргааны байгууллагад үйлчилгээ үзүүлэх, дулаан түгээх үйл ажиллагаа, хадлан тэжээл бэлтгэх, зочид буудлын үйлчилгээ гэсэн 4 төрлөөр тодорхойлсон байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ хэлбэрээр төрийн 100 хувийн өмчлөлтэй, Дарьганга суманд харьяалагдаж, үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан газар, айл өрх, нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг цэвэрлэх зөөх, тээвэрлэх, булах, устгах
- Айл өрх, албан газар, ААНБ, иргэдийн хэрэгцээний ундны усны зөөвөр, хангалт
- Сумын нөөцөд зориулан хадлан тэжээл бэлтгэх, борлуулах
- Сумын төвийн айл өрхийг хаягжуулах, хашаа, барилга, байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулах, нийтийн эзэмшлийн газрыг тохижуулах, мод зүлэг тарих, хашаа хайс татах
- Бүтээн байгуулалт, үйлдвэр үйлчилгээний ажил хийх
- Хууль тогтоомжоор хориглоогүй үндсэн үйл ажиллагаатай зөрчилдөхгүй бусад үйл ажиллагааг эрхэлж ашиг олох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,761.2 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	301.4	383.4	82.0
<b>Авлага</b>	12,200.5	9,359.0	(2,841.5)
<b>Бараа материал</b>	9,496.5	10,983.6	1,487.1
<b>Үндсэн хөрөнгө</b>	771,725.2	746,683.2	(25,042.0)
<b>Биет бус хөрөнгө</b>	4,692.2	14,245.3	9,553.1
<b>Нийт хөрөнгө</b>	798,415.7	781,654.5	(16,761.2)
<b>Өр төлбөр</b>	794,906.4	804,102.5	9,196.1
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	3,509.3	(22,448.0)	(25,957.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	798,415.7	781,654.5	(16,761.2)

Харилцах дансны үлдэгдэл 383.4 мянган төгрөг болж 82.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэлд 9,359.0 мянган төгрөг болж 2,841.5 мянган төгрөгөөр буурсан нь айл өрх, ААНБ-ын усны хэрэглээг төрөөс санхүүжүүлсэнтэй холбоотой 2021 оны 12 сарын авлагыг барагдуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд шинээр үнэ төлбөргүй 49,645.6 мянга, худалдан авсан 300.0 мянга, нийт 49,945.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 804,102.5 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 9,196.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн бөгөөд тус хөрөнгө элэгдлийн зардлаараа буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дарьганга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 267,012.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 261,123.1 мянган төгрөгөөр, 5,889.7 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 265,468.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 301,171.2 мянган төгрөгийн зардал гарган, 35,703.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 265,468.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,544.6 мянган төгрөг буюу 0.6 хувиар буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 301,171.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 38,010.2 төгрөг буюу 15.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 303,573.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 6,071.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,250.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,813.1 мянган төгрөгөөр буурсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,632.8	1	1,332.8	63
Зөвлөмж	1	-	1	-	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>3,632.8</b>	<b>2</b>	<b>1,332.8</b>	<b>81.5</b>

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 зөрчил<sup>2</sup> илэрснээс төлбөрийн акт тогтоолоо.

<sup>1</sup> Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

